



**“БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЖ,
ЭРХ ТЭГШ, МЭДРЭГ БОЛГОХЫН ТӨЛӨӨ”**

**Боловсролын санхүүжилтийн талаар баримтлах иргэний нийгмийн
байр суурийн баримт бичиг**

**Улаанбаатар хот
2025 он**

I. БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ БОЛ ЗАРДАЛ БИШ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Боловсролыг дэлхий нийтийн хөгжлийн томоохон хурдасгуур хэмээн хүлээн зөвшөөрч, 2015 онд Тогтвортой Хөгжлийн Зорилго 4-ийг “Хэнийг ч ардаа үл орхих чанартай, тэгш хамарсан, эрх тэгш боловсрол ба насан туршийн суралцахуй” хэмээн тодорхойлж, улсын төсвийн зардлын наад зах нь 20%, эсвэл дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 4-6 хувийг боловсролын салбарт зарцуулах амлалт авсан байдаг.

Ийнхүү тодорхойлсон шалтгаан нь “Хүн бүр сурч боловсрох эрхтэй” буюу улс орон бүр энэхүү эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэгтэй тухай олон улсын хууль, эрх зүйн хүрээ, үндэсний хууль тогтоомжийн заалтууд билээ. Хүн бүрт үнэ төлбөргүй, чанартай боловсрол заавал эзэмших эрхийг эдлүүлэх үүрэг хариуцлагыг төр хүлээдэг. Улсын төсвийн орлого, төсвийн хуваарилалт нь төр сурч боловсрох эрхийг хангах үүргээ биелүүлэх нэг гол арга хэрэгсэл байдаг. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пактад зааснаар оролцогч улс бүр хүний эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн болон хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх нөөц боломжоо дайчлан авах үүрэгтэй.


Улс орон урт хугацаанд хийж болох хамгийн үр өгөөжтэй хөрөнгө оруулалт бол боловсролын салбарт зориулах зардал гэдгийг олон улсад хүлээн зөвшөөрөөд байна. Бүх нийтийн чанартай боловсролд хөрөнгө оруулах нь эдийн засгийн өсөлтийг өдөөж, тэгш бус байдлыг бууруулж, хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулж, нийгмийн эв эеийг бэхжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн давах чадвартай амар амгалан нийгэм байгуулах, улмаар хүний эрхийг хангахад хувь нэмрээ оруулдагийг эдийн засагчид нотолж байна.

Төрөөс боловсролд зориулж буй төсвийн зарцуулалт-хөрөнгө оруулалтын доллар бүр ДНБ-ийг дунджаар 20 дахин нэмэгдүүлдэг гэсэн тооцооллыг Дэлхийн Банкнаас хийсэн байдаг. Боловсролтой хүмүүс улс орондоо инновацийг нэвтрүүлж, бүтээлч бизнес санаа, дэвшилтэт технологи бий болгох хандлагатай байгаа нь эргээд илүү олон ажлын байр бий болгож, улс орны хувийн хэвшлийн хөгжлийг хурдасгадаг. Хэрвээ хүүхэд, залуу хүн бүр сургуульд сурч байсан бол энэ нь дэлхийн ДНБ-ийг жилд 6.5 их наяд доллараар нэмэгдүүлэх байсан гэдгийг ЭЗХХАБ 2024 онд тооцоолжээ. Эдийн засгийн өсөлтийг хангах хамгийн үр дүнтэй стратегийн нэг нь эрсдэлт бүлгийн бага насны хүүхдүүдийн хөгжилд хөрөнгө оруулах явдал гэдгийг тоо баримт харуулж байна. Боловсролд зориулсан жил бүр тухайн хүний жилийн орлогыг 9 орчим хувиар нэмэгдүүлдэг.

Боловсрол бол хүний үндсэн эрх төдийгүй бусад эрхээ эдлэх боломжоор хангагч юм. Чанартай боловсролд төсөв зарцуулах нь иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ардчилсан зарчмуудыг төлөвшүүлж, хүчирхийллийг бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлж, нийгмийг тэгш хамруулсан, эрх тэгш, нээлттэй болгодог. Хүйсийн тэгш эрхийг хангасан боловсролын тогтолцоо нь эрт гэрлэлт, өсвөр насны жирэмслэлт, жендэрт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэл зэрэг хор хөнөөлтэй үйлдлүүдийг таслан зогсооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Суралцагчдыг хүчирхийллийн аргаар асуудлыг шийдэх нөлөөнд автахгүй байх, интернет болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй үзэн ядсан агуулга бүхий мэдээллийг эсэргүүцэх чадавхийг боловсрол бий болгоно. Боловсрол нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн сөрөг нөлөөллийг даван туулахад болон уур амьсгалын шударга ёсыг тогтоох, байгаль орчныг хамгаалах зан үйлийн өөрчлөлтийг хийхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг хувь хүн, нийгмийн бүлгүүдэд эзэмшүүлэхэд чухал үүрэгтэй.

1.1. Өнөөгийн нөхцөл байдал

Харамсалтай нь ЮНЕСКО, Эдийн засаг хөгжил, хамтын ажиллагааны байгууллага (ЭЗХХАБ) хамтран боловсролын салбарт хөрөнгө оруулалт дутмаг байдал нь тэгш бус байдлыг гүнзгийрүүлэхээс гадна, эдийн засагт хүндрэл учруулахуйц их зардал дагуулж, мэргэжлийн суурь ур чадварт хөрөнгө оруулалт хангалтгүй хийгдсэнээс жил бүр 10 их наяд долларын алдагдал хүлээхээр байгаа тооцооллыг хийсэн.



Ази Номхон далайн бүсийн ихэнх орнуудад Боловсролын санхүүжилтийн хэмжээ амласан зорилтот түвшиндээ хүрэхгүй байна.

Дэлхий даяар жил бүр боловсролд 97 тэрбум долларын санхүүжилт дутагдаж байна.

Монгол улсад сүүлийн жилүүдэд боловсролын салбарын санхүүжилт тогтвортой нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа ч хангалттай биш, нэг суралцагчид 1 жилд зарцуулдаг зардал туйлын хангалтгүй байгаа нь боловсролын хүртээмж, чанар, эрх тэгш байдалд нөлөө үзүүлсээр байна. Сургуулийн өмнөх боловсролд төсвийн

томоохон хувь ногддог ч хүртээмж нь жигд бус хэвээр, энэ нь малчин өрхийн болон эмзэг бүлгийн хүүхдүүдийн хувьд тод илэрч байгааг Монгол улсын төсвийн судалгаанд (2025) дурджээ.

Дотоодын буюу төсвөөс санхүүждэг улсын боловсролын тогтолцоонд хувьчлах, хувийн хэвшлийн хяналт, хариуцлагагүй оролцоог дэмжих, төр-хувийн хэвшлийн түншлэлийг нэвтрүүлэх оролдлогууд хийгдэж байгаа нь МБШУҮЭ-ийн холбоо ба Боловсрол эвслийн санааг зовоож байна.

II. БИДНИЙ САНАЛ БОЛГОЖ БАЙГАА БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТИЙН 4S ЗАРЧИМ

Дэлхий даяар боловсролын санхүүжилтийн 97% нь дотоодын эх үүсвэрээр буюу улсын төсвөөс, ердөө 3% нь гадны зээл, тусламжаас бүрддэг учир дотоодын санхүүжилт амин чухал юм. Боловсролын асуудлаар шийдвэр гаргадаг төрийн байгууллага, албан хаагчид боловсролын салбарын санхүүжилтийн 4S байдлыг (4S Framework in Education Financing) нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатайг бид сануулж байна:

1. **Төсөвт эзлэх хувийг (SHARE) нэмэгдүүлэх**- Боловсролд хуваарилж буй улсын төсвийн хувь хэмжээг нэмэх (наад зах нь улсын төсвийн зарлагын 20%, ДНБ-ий 6%)

2. **Төсвийн нийт хэмжээг (SIZE) нэмэгдүүлэх** -Улсын нийт төсвийн хэмжээг нэмэгдүүлж, орлогын эх үүсвэрийг шударгаар өсгөх (татвар, эдийн засгийн бодлого)

3. **Төсвийн хуваарилалтын мэдрэг байдлыг (SENSITIVITY) нэмэгдүүлэх** - Төсвийг боловсролын тэгш бус байдлыг арилгахад чиглүүлэх, нотолгоонд суурилан үр дүнтэй байх (маргиналчлагдсан бүлгийн суралцахуй, хөгжилд тулгарах саадыг арилгах)

4. **Төсөвт тавих бодит хяналтыг (SCRUTINY) сайжруулах**- Иргэд, иргэний нийгмийн оролцоо, ил тод байдал, тайлагналын механизмыг бэхжүүлж, үр дүнг хянах (ингэснээр төсвийн үр ашигтай зарцуулалтыг хянаж, өгөгдлийн чанар сайжирч, өгөгдлийг ашиглах чадавхи нэмэгддэг)

Үүний тулд Боловсролын салбарын багш ажилтнуудын ҮЭ ба ИНБ-ууд төсвөөс төрийн үйлчилгээний салбарыг санхүүжүүлэх бодлогыг хамгаалах, татварын шударга ёсыг шаардах, өрийн дарамтад орохоос урьдчилан сэргийлэх, олон улсын банк санхүүгийн байгууллагын төсөв танах, царцаах зэрэг нөхцөл болзлыг эсэргүүцэх зэрэг асуудлаар олон улсын болон үндэсний түвшинд нэгдэн ажиллах болно.

Монгол улсын төрийн тэргүүн ч НҮБ-ын Боловсролыг хувьсган өөрчлөх санаачилгад нэгдэн “Боловсролын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд олон талын оролцоог хангах, санхүүжилтэд инновацыг нэвтрүүлэх, үр дүнд суурилсан төлөвлөлт, хяналтыг бий болгох” амлалтыг авсан билээ. Үүнд “сургалтын байгууллагын үйл ажиллагаа, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хяналт, үнэлгээнд эцэг, эх, суралцагч, иргэний нийгмийн байгууллага болон бусад оролцогч талуудын идэвхтэй оролцоог хангадаг болох” амлалт багтаж байгааг сануулах нь зүйтэй.


Дээрх 4S зарчмыг улс орондоо нэвтрүүлснээр улсын сургуулиудад төсвийн хангалттай санхүүжилт хүрч, төрөөс өөрсдөд байгаа нөөц бололцоог дээд зэргээр дайчлан зориулж, хүүхэд, залуусын сурч боловсрох эрхийг ханган, Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилго биелүүлэх боломжтой гэж бид үзэж байна.

2.1 Боловсролын төсвийн улсын төсөвт эзлэх хувийг нэмэгдүүлэх

Боловсролын салбарт төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх нь улс орны хийж чадах хамгийн сайн, урт хугацааны хөрөнгө оруулалт. Энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж, тэгш бус байдлыг бууруулж, нийгмийн эв нэгдэл, ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлж, хүний эрхийг хангах, эрх тэгш, хүртээмжтэй, нээлттэй нийгмийг бий болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ялгаварлан гадуурхах үзлийг багасгах, нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг бий болгох үр нөлөөтэй. Боловсрол эзэмших түвшин дээшилснээр дэлхийн хамгийн ядуу бүлгийн орлогын өсөлтийн 70%-д шууд нөлөөлсөн бөгөөд 1980 оноос хойш туйлын ядуурлыг 40%-иар бууруулсан байна.

Гэвч дэлхий нийтээр засгийн газрууд ихэвчлэн богино хугацааны үр дүнд зорьж, боловсролд зориулж буй төсөв, мөнгийг “хөрөнгө оруулалт” гэж хүлээн зөвшөөрөхөөс илүү “зардал” гэж харсаар байна. Иймээс улс орнууд боловсролд хангалттай хөрөнгө оруулалгүй цааргалснаар хөгжлийн зорилгууддоо хүрч чадахгүйд хүрдэг чөтгөрийн тойргоос гарахын тулд суурь сэтгэлгээгээ өөрчлөх ёстой.

Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгаагаар боловсролд хамрагдсан нэг жил бүрт хөдөлмөр эрхлэх боломж 6.5%-иар нэмэгддэг. Монгол банкны тооцооллоор боловсролд хамрагдсан жил нэгээр нэмэгдэхэд хөдөлмөрийн орлого 3.8%-иар өсдөг байна. Дэлхийн банкны 2024 онд хийсэн тооцооллоор, иргэдийн 2021 оны худалдан авах чадварыг тухайн жилийн хөдөлмөрийн бүтээмжтэй харьцуулахад 14.0 мянган ам.доллар байсан бөгөөд, хэрэв тухайн жилийн хөдөлмөрийн бүтээмж Сингапур улсын бүтээмжийн түвшинтэй ижил түвшинд байсан бол худалдан авах чадвар 18.4 мянган ам.доллар байх боломж байгаа нь боловсролын салбарт хөрөнгө оруулалт хангалтгүйгээс үүдэн бид 5.7 тэрбум ам.долларын боломжийг алдсан гэсэн дүгнэлт гарчээ. Иймээс боловсролоор дамжуулан хүний хөгжилд хийж байгаа хөрөнгө оруулалт нь эдийн засгийн ирээдүйн өсөлтөд хийж буй хөрөнгө оруулалт юм.



Инчеоны тунхаг ёсоор улс орнууд боловсролын салбарт улсын төсвийнхөө 20-иос доошгүй хувийг зориулах шаардлагатай бөгөөд хамгийн бага орлоготой орнуудад чанартай боловсрол олгохын тулд төсвийн 20-иос илүү хувийг зарцуулах шаардлагатай гэж зөвлөдөг. Улсын төсөвт эзлэх боловсролын төсвийн хувь хэмжээ чухал бөгөөд дэлхийн дундаж нь ердөө 14.1% байгаа нь боловсролын хөрөнгө оруулалт хангалтгүй гэдгийг харуулж байна. (GEMR, 2023)

2.2 Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх;



2022 онд болох НҮБ-ын “Хувирган өөрчлөх боловсрол” төрийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтаар боловсролын салбарт ахиц дэвшил гаргахын тулд засгийн газрын төсвийн нийт санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах нь чухал болохыг онцолсон. Тодруулбал татвар, ер, хэмнэлтийн асуудлаар арга хэмжээ авах шаардлагатай байгааг тэмдэглэв.

2.1. Татварын талаар авах арга хэмжээ

Улсын төсвийн зардлын боловсролын болон төрийн бусад үйлчилгээний ихэнх хувийг татварын орлого бүрдүүлэгч ихэнх улсад татварын нийт орлого байж болох хэмжээнээс доогуур байдаг. Бага орлоготой орнуудын ДНБ-д эзлэх татварын дундаж хэмжээ ердөө 16% байдаг бол дундаж орлоготой олон оронд 25% буюу 30%, Эдийн Засаг, Хөгжлийн Хамтын Ажиллагааны Байгууллага (ЭЗХХАБ)-ын дундаж 33%, Скандинавын орнуудад 40%-иас дээш байдаг. ТХЗ-ыг хэрхэн санхүүжүүлэх тухай Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн гол баримт бичигт 2030 он гэхэд бага, дунд орлоготой ихэнх орнууд татвараас ДНБ-д эзлэх хувь хэмжээгээ таван пунктээр нэмэгдүүлэх боломжтой гэж зөвлөсөн байдаг. Хамгийн сүүлийн үеийн судалгаагаар Боловсролын төлөөх дэлхийн түншлэлийн 89 түнш орон энэхүү зөвлөгөөг дагаснаар жил бүр 455 тэрбум ам.доллар нэмж босгох боломжтой бөгөөд үүний 20 хувийг боловсролд зарцуулбал жил бүр боловсролын салбарт 93 тэрбум гаруй ам доллар зориулах боломжтой бөгөөд энэ нь боловсролын системийг өөрчлөхөд хангалттай санхүүжилт юм.

Төсвийн бодлогын хамгийн чухал хэсэг нь татварын тогтолцоог илүү шударга болгох явдал юм. Энэ нь татварын өсөн нэмэгдэх тариф буюу орлого ихтэй хэсэг нь нийгмийн өмнө илүү өндөр хариуцлага хүлээх тогтолцоо юм. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг олборлож буй компаниудад илүү татвар ногдуулах нь энэ зарчмын бас нэг хэсэг юм. Хувирган өөрчлөгдөх боловсролын баримт бичигт "Татварыг хамгийн өндөр орлоготой 0.1% - 1% -н бүлэгт чиглүүлэх нь амин чухал боловч илүү шударга тогтолцоо бий болгохын тулд 10% эсвэл 20% -д зарим ачааллыг шилжүүлнэ" гэж тэмдэглэжээ. Боломжтой бол татварын шинэчлэлийг жендэрийн мэдрэмжтэй, уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэг болгох тохиолдол бас бий

Сүүлийн 60 жилийн хугацаанд дэлхийд тогтсон татварын тогтолцооны цоорхойг ашиглан татвараас зайлсхийж татварын диваажинд өөрийн орлогоо нуун дарагдуулах зэргээр тухайн улсад татварын шинэчлэлийг нэвтрүүлэхэд саад учрах боломжтой. Хувирган өөрчлөгдөх боловсролын санхүүжилтийн хүрээнд үндэсний татварын тогтолцоог олон улсын бодлоготой уялдуулан дэлхийн хөрөнгийн

бүртгэлийг цэгцлэх, санхүүгийн хууль бус урсгалыг бууруулах, татварын диваажинг хаах, дэлхийд татварын шинэ дүрмийг тогтооход чиглэж байна.

Өрийн талаар авах арга хэмжээ

Өдгөө өрийн хямралд орсон 54 орон, Боловсролын төлөөх дэлхийн түншлэлийн 25 түнш улс өр барагдуулах зардалд боловсролоос илүү их мөнгө зарцуулж байгаа. Хувирган өөрчлөх боловсролын Санхүүгийн баримт бичигт өрийн талаар яаралтай арга хэмжээ авахыг уриалж, "Өрийн хямралд орсон орнуудын өрийг дахин хэлэлцэх, тэр байтугай өрийг тэглэх арга хэмжээг нэн даруй эрчимжүүлэх шаардлагатай. Боловсролоос илүү өр барагдуулахад төсвөө зарцуулж байгаа аливаа улс орнуудад тэргүүлэх ач холбогдол өгөх ёстой. Гэсэн хэдий ч боловсрол өрийн асуудлаар үндэсний болон дэлхийн хэлэлцүүлэгт чухал дуу хоолойгоо хүргэхгүй байгаа явдал юм. ОУВС эцсийн шатны зээлдүүлэгч болж, өр зээлээ ашиглан өртэй орнуудад хатуу хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж, цаашлаад боловсролын зардлыг хумьдаг.

Өрийн асуудлаар олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх зайлшгүй шаардлага байгаа бөгөөд НҮБ-ын дэргэд өрийн хямралыг шийдвэрлэхэд ил тод, албадан шинжтэй, олон талт тогтолцоог бий болгож, өрийн дарамтад ихээр өртсөн улс орны өрийн хямралыг шийдвэрлэх шинэ механизмыг бий болгохоор урагшилж байна. Энэ нь ОУВС-г үйл явцаас холдуулж, бүх зээлдүүлэгч талуудыг цуглуулан тогтворгүй, хууль бус өрийн асуудлыг шийдэх, өр тэглэх зэрэг өрийн бүтцийг системтэй, цаг алдалгүй, шударгаар өөрчлөх боломжийг олгоно.

2.2 Хэмнэлтийн бодлоготой холбоотой авах арга хэмжээ

ОУВС улс орнуудад өр төлбөрөө төлж, тэнцвэржүүлэхийн тулд төсвийн нийт зардлыг танаж, хэмнэлтийн бодлого баримтлахыг байнга зөвлөдөг. Боловсролын салбар засгийн газрын төсвийн зардлын томоохон хувийг эзэлдэг тул ихэвчлэн пропорциональ бус байдлаар хохирдог. ОУВС-гийн зөвлөгөө нь маш тодорхой байдаг бөгөөд төрийн албан хаагчдын цалингийн санг бууруулах эсвэл царцаахыг санал болгодог бөгөөд багш нарын цалингийн сан томоохон хэсгийг бүрдүүлдэг учраас боловсролын салбар ихээхэн өртдөг - олон багшид төлөх мөнгө байхгүй (багшийн дутагдалтай байсан ч), багш нарт илүү цалин өгөх мөнгө байхгүй (хичнээн бага цалинтай байсан ч). НҮБ-ын Багшийн мэргэжлийн дээд зөвлөл дэлхий даяар багшийн хомсдол байнга өссөөр байгаа бөгөөд дэлхийн улс орнуудын тал хувь нь багш нар ижил төстэй ур чадвар шаарддаг бусад мэргэжлээс бага цалин авдагийг онцгойлон сануулдаг. ActionAid-ийн судалгаанаас үзэхэд ОУВС-аас төрийн албан хаагчдын цалинг бууруулах, царцаахыг зөвтгөх тодорхой логик, үндэслэл, нотолгоо байхгүй байна.

ОУВС-аас хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх зөвлөмжийн хариуд боловсролын түвшин бүрт багшийн хомсдол ямар байгаа талаарх мэдээллийг бэлтгэн өгөхийг НҮБ-с зөвлөдөг. Төрийн үйлчилгээний албан хаагчид зэрэг тэргүүн эгнээнд ажиллаж буй төрийн албан хаагчдын дутагдлыг арилгахын тулд төсвийн байгууллагын цалингийн хэмжээг ДНБ-д эзлэх хувиар нэмэгдүүлэх нь үндэслэлтэй.

Дэлхийн дундаж 9% -д хүрэхийн тулд цалингийн хэмжээг идэвхтэй нэмэгдүүлэх. Төсвийн зардлыг танахаас илүүтэйгээр татварын орлогыг нэмэгдүүлэхэд анхаарах (ОУВС-гийн дээр дурдсан гол зөвлөмжийн дагуу). 2022 онд болсон Төрийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтаар тохиролцсон санхүүжилтийн талаар уриалга нь “ОУВС болон бусад олон улсын санхүүгийн байгууллагуудыг боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэхэд саад болж буй төрийн албан хаагчдын цалингийн хязгаарлалт зэрэг одоо байгаа саад бэрхшээлийг арилгахыг; Мөн хаана ч дутагдалтай байгаа мэргэжлийн багш нарыг шинээр ажилд авах боломжийг олгох бодлогыг дэмжих. Цаашилбал, НҮБ-ын Багшийн мэргэжлийн дээд зөвлөл “Төсвийн зарцуулалтыг ил тод болгох, хэмнэлтийн арга хэмжээ зэрэг ОУВС-аас хэрэгжүүлж буй бодлогоор хамгаалагдсан байх ёстой” гэж зөвлөж байна.” (зөвлөмж 7). Үүний оронд багш нарт “өрсөлдөхүйц цалин, урамшуулал; өндөр чанартай, хүртээмжтэй, хямд багшийн мэргэжлийг дээшлүүлэх сургалт; мэргэжлийн тасралтгүй хөгжил болон чанартай сургалтын хэрэглэгдэхүүн; мэргэжил дэмжих мэргэшсэн боловсон хүчнээр хангах хэрэгтэй” (зөвлөмж 8).

2.3 Төсвийн мэдрэг байдлыг нэмэгдүүлэх

Боловсролд эрх тэгш байдлыг баталгаажуулах нь боловсролын салбарын санхүүжилттэй нягт холбоотой. Тогтвортой хөгжлийн 4-р зорилгын үндсэн үзэл санааны нэг болох Эрх тэгш байдал гэж юу вэ? “Тэгш хамралт ба боловсрол: Бүх нийт гэсэн бол бүх нийт л байх ёстой” гэсэн нэрээр гарсан Боловсролын хяналт шинжилгээний 2020 оны дэлхийн тайланд тодорхойлсноор: “... ТХЗ 4-ийн гол суурь нь ”тэгш хамруулсан, эрх тэгш” боловсрол... Тэгш байдал гэдэг нь аливаа үйлийн нөхцөлт байдал (юу): орц буюу нөөц, гарц буюу шууд үр нөлөө эсвэл дам үр дүн. Эрх тэгш байдал бол үйл явц (хэрхэн): тэгш байдлыг баталгаажуулахад чиглэсэн үйлдэл.”

Өөр нэгэн эх сурвалжийн тайлбарласнаар боловсрол дахь эрх тэгш байдал



гэдэг нь “хүүхэд бүрд амжилт гаргахад нь шаардлагатай байгаа нөөц, багш, үйл ажиллагаа, дэмжлэг” юм. Энэ нь хүн бүрд ижил зүйлийг тэгш байдлаар өгөх тухай асуудал биш, харин хувь хүний нөхцөл болон хэрэгцээг тооцож үзэж буй явдал юм. Боловсролд эрх тэгш байдлыг баталгаажуулах нь боловсролын салбарын санхүүжилттэй нягт холбоотой. Хэрэв нөөцийг зөвхөн аль нэг бүлэгт чиглүүлбэл энэ нь бусад бүлэгт ноогдох нөөцөөс авч байна гэсэн үг.¹ Тэгэхээр эрх тэгш байдал гэдэг нь зөвхөн тодорхой нэг бүлгийн асуудлыг хөндсөн бус, бүх нийтэд боловсролыг хүртээмжтэй болгоход чиглэсэн хүмүүнлэг, хүний эрхийг дээдэлсэн зарчим юм.


Зарим тохиолдолд эрх тэгш байдлыг хангахын тулд ядуурал, байршил зэрэг хүчин зүйлийг тусгадаг. Гэхдээ энэхүү санхүүжилтийн хэмжээ нь [орон нутгийн

¹ The Leadership Conference Education Fund 2015

санхүүгийн нөөц дайчлах чадавх, боломжоос шалтгаалан] ихээхэн зөрүүтэй байдаг учраас тэгш бус байдалд нөлөө үзүүлдэг.

Маргинал, орхигдож гадуурхагдсан бүлгийн хүүхэд, залуус, насанд хүрэгчид боловсролын тогтолцооны гадна хэвээр, боловсролд хамрагдсан хэдий ч амжилттай суралцаж чадахгүй суралцахуйн хоцрогдолд орж байна. Ажилгүйдэл, ядуурал, жендэрийн тэгш бус байдал, хүчирхийлэл, өвчлөл, байгаль орчны доройтол, хүнд ээлтэй бус хот төлөвлөлт зэрэг олон тогтолцооны хүчин зүйлүүд хүүхэд, залуусын сурч боловсрох эрхэд саад болсон хэвээр байна. 2021 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын санаачилгаар Хувирган өөрчлөх боловсрол, “Ирээдүйгээ хамтдаа төсөөлөхүй: Боловсролын нийгмийн шинэ гэрээ” үзэл санаа, бодлогын баримт бичиг, судалгаануудыг гаргаж, Засгийн Газрууд дахин амлалт авч, ТХЗ 4: Чанартай боловсролын зорилго нь бусад зорилгуудаа хурдасгах хүч болохыг дахин тунхаглав.

Финландын нэрт боловсрол судлаач Паси Сахлбергийн бүтээлд эрх тэгш байдлын төлөөх санхүүжилт буюу боловсролын системээ илүү тэгш байлгахын тулд



хөрөнгө оруулалт хийж байгаа улс орнуудын боловсролын чанарт мэдэгдэхүйц ахиц гардагийг нотолсон байдаг. Энэ нь дэлхийн ранкаар амжилтаа ахиулах зорилготой боловсролын системээс ялгаатай, учир нь цөөн хэдэн сурагчид амжилтанд хүрч болох ч боловсролын салбарын ерөнхий гүйцэтгэл, эрх тэгш байдал ихэвчлэн буурдаг. Сахлбергийн нотолгоо ёсоор эрх тэгш байдалд анхаарлаа хандуулах нь хүн бүрт ашигтай бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш

хамруулан сургах, боловсрол дахь жендэрийн эрх тэгш байдалд онцгой анхаарах хэрэгтэй. Нийгэм эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүд, хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт амьдардаг хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон бусад маргинал бүлэгт чиглэсэн бодлого хэрэгжүүлж, хөрөнгө оруулах хэрэгтэй. Сургуулийн өмнөх боловсролоос эхлээд бүх шатны боловсролын тогтолцоонд эрх тэгш байдалд онцгой анхаарах ёстой. Чанартай боловсролыг эрх тэгш хүргэхийн тулд бага наснаас эхлээд өндөр чанартай, үнэ төлбөргүй олон нийтийн боловсрол, асаргаа халамж нь чухал юм.


Боловсролын төсвийн зарцуулалтын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх бусад арга хэмжээнд хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх болон багшийн менежментэд хөрөнгө оруулах зэрэг орно. Төсвийн төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжүүлэх, хяналтын явцад өгөгдөлд маш чухал учир найдвартай өгөгдлийн сантай болоход анхаарах. Мөн төсөвлөлтийн явцад боловсролын салбарыг тусад авч үзэлгүй бүтэн зургаар нь харж харах, эрүүл мэнд, ус, эрчим хүч зэрэг бусад засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллагуудын төсөвлөлтөд боловсролын салбарт нөлөөтэй хөрөнгө оруулалтын уялдаа холбоог хангах төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.

Дөрвөн улс тутмын нэг нь дээд боловсролд хамрагдахад дэмжлэг үзүүлдэг хөтөлбөртэй. Боловсролын бус тодорхой санхүүжилтийн бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.

Латин Америкийн орнуудад урт удаан хугацааны туршид хэрэгжсэн нөхцөлт мөнгөн тэтгэмжүүд нь боловсролд хамрагдсан хугацааг 0.5-1.5 жилээр нэмэгдүүлсэн байна. Бага болон дунд орлоготой улс орнуудад 310 сая орчим суралцагч сургуулийн хоолны хөтөлбөрт хамрагддаг.²

2.4 Төсөвт тавих хяналтыг сайжруулах

Зөвхөн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр боловсролын чанар сайжрахгүй, харин нэгдсэн урт хугацааны бодлого, төлөвлөлт, олон нийтийн хяналт, ил тод байдал, эгэх хариуцлагын механизмыг сайжруулах боломжтой.



Хэрэв олон нийт төсвийн үр ашигтай, үр дүнтэй зарцуулалтад итгэх итгэл байхгүй бол төсөвт эзлэх хувийг нэмэгдүүлэхэд нөлөөлөх хэцүү. Улсын, орон нутгийн, сургуулийн түвшинд төсөвийн явцад олон нийтийн оролцоо, хяналт, аудитын тогтолцоог сайжруулсанаар төсвийн зарцуулалтын үр ашиг, ил тод байдлыг сайжруулна. Энэ нь төрийн байгууллага болон үйлчилгээг бүх шатанд эгэх хариуцлагатай, иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр төсвийн үргүй зардалыг бууруулахад чухал нөлөөтэй.

Боловсролд зориулсан төсвийг зориулалтын бусаар ашигласан, зарцуулсан нь тогтоогдсон албан тушаалтан, эрх мэдэлтэн болон хамаарал бүхий хүмүүст хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхийн тулд хариуцлагын тогтолцоог тодорхой болгох. Төрөөс боловсролын төсөвт олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх бүхий л хүчин чармайлтыг идэвхтэй дэмжиж ёстой, үүний үр дүнд боловсролын зардлыг үр дүнтэй зарцуулж байна гэсэн иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх болно.

² How committed? Unlocking financing for education, UNESCO, 2021

III. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсад боловсрол олгох үйл ажиллагаа зардал ихээр шаарддагийг тооцож үзэн улсын төсвийн зарлагын наад зах нь 20%, ДНБ-ий 6%-д боловсролын төсвийг хүргэх шаардлагатайг судлаачид зөвлөдөг. Боловсролын салбарын тойм судалгаанд дараах гурван шалтгаанаар тайлбарласан байдаг. Үүнд:

- газар нутаг уудам бөгөөд хүн ам нь тархай суурьшдаг тул боловсролын үйлчилгээг хүргэх зардал өндөр

- удаан үргэлжлэх өвлийн хүйтэн улирлаас хамааран дулаан, халаалтын зардал өндөр.

- боловсролын салбар нь хөдөлмөр багтаамж болон орц ихтэй салбар учраас бусад салбартай харьцуулахад цалингийн зардал өндөр гардаг нь боловсролын үйлчилгээг хүргэх зардлыг ихээр нэмэгдүүлж байна. багш бус ажилтнуудын

- мөн хүн амын 28 хувийг малчин өрхүүд эзэлдэг, 300 гаруй суманд буй малчдын хүүхдийг сургах дотуур байрны зардал,

- хувийн цэцэрлэг, сургуулиудад өгөх төсвийн татаас зэргийг нэмбэл боловсролын зардал бусад ижил хөгжлийн түвшинтэй өндөр болно гэж бид тооцсон.³

2022 оноос нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативыг нэмсээр байгаа ч сургалтын үйл ажиллагааг хэвийн нөхцөлд явуулахад хүрэлцэхгүй, тухайлбал сургуулийн үйл ажиллагааны урсгал зардлыг бүрэн даахгүй, эцэг эхээс төлбөр хураамж авсан хэвээр байна.

Монгол улсын УИХ-аас 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Боловсрол бол хүний хөгжлийн чухал хөдөлгүүр бөгөөд улс орны хөгжлийн суурь юм” гэж заажээ. Уг баримт бичигт боловсролын дараагийн 30 жилийн хөгжлийн бодлогыг хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлсэн, тэгш хамруулан сургах, насан туршдаа суралцах боломжийг баталгаажуулсан боловсролын тогтолцоо байна хэмээн тодорхойлсон. Боловсролын санхүүжилтийн талаар дараах зорилтууд тусгагдсан байна:

- 2.1.4. Сургалтын байгууллагын санхүүжилтийг төгөлдөржүүлэн, суралцагч нэг бүрийг амжилттай суралцахад чиглүүлнэ.
 - 2.1.11. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.
 - 2.1.12. Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.

³ Боловсролын салбарын төсвийн санхүүжилтэд үзүүлэх Монгол улсын нийт өрийн судалгаа, Боловсрол эвсэл 2021 он


Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийн нэг нь "ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан боловсролын салбарын шинэчлэл" байхаар төлөвлөж, 2025 оны Засгийн Газрын 158-р тогтоолоор 2026 оныг "Боловсролын жил" болгон зарласан. Үүнд боловсролын хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлж, төсвийг Тогтвортой хөгжлийн зорилгын зорилтот түвшинд хүргэж нэмэгдүүлэхээр тусгажээ.



Сүүлийн 10 жилд Боловсролын салбарт хуваарилж буй санхүүжилт Монгол улсын төсвийн нийт зарлагад эзлэх дундаж хувь 15.5%, ДНБ-д эзлэх дундаж хувь 4.7% байсан ⁴ Судлаач Б.Отгонтөгс 2021 онд хийсэн Боловсролын салбарын төсвийн санхүүжилтэд үзүүлэх Монгол улсын нийт өрийн судалгаандаа гадаад өрийн төлбөр нэмэгдэх зэрэг ямар ч гэнэтийн нөхцөл байдалд боловсролд зориулах санхүүжилтыг бууруулж болохгүй гэж зөвлөсөн байдаг. Гэвч Боловсролын жил гэж зарласан 2026 оны төсвийн төсөлд


боловсролын салбарт хуваарилж буй санхүүжилт ДНБ-ий 3,6% байхаар тогтсон нь сүүлийн хэдэн арван жилийн хамгийн доод үзүүлэлт юм.

Эдийн засгийн хямрал, цар тахал, өрийн дарамт зэргээс үл шалтгаалан боловсролын салбарын төсвийг таналгүй, харьцангуй тогтвортой түвшинг хадгалж ирсэн байдаг.




⁴ 2024 оны Улс төрийн намын мөрийн хөтөлбөрт тусгах санал, Боловсрол эвсэл

Сүүлийн арван жилд Монгол улсын гадаад өр ДНБ-ий 40 хувиас 240 хувь болтлоо огцом нэмэгдэж, өрийн дарамт үүссэн бөгөөд боловсролын санхүүжилт өмнөх жилүүдийн түвшинд хадгалагдана гэж эдийн засагчид үзжээ.



Олон улсын сурлагын амжилтын үнэлгээгээр (PISA) Монголын 15 настай хүүхдүүдийн сурч байгаа сургуулийн боловсрол сургалтын материал хэрэглэгдэхүүн, барилга байшингийн хүртээмж, чанар ЭЗХХАБ-ын ба Азийн улс орнуудын дундаж төдийгүй хөгжлийн адил түвшинтэй улсуудтай харьцуулахад нэлээд доогуур байна гэсэн дүн гарсан. Мөн түүнчлэн энэ үнэлгээнд амжилттай гэж үнэлүүлдэг улс орнууд нэг суралцагчид ногдох зардал 6-15 насанд нь өсөн нэмэгдэх дүнгээр дунджаар 91,132 ам.доллар зарж байхад Монгол улс 12,576 ам.доллар буюу 7 дахин бага байна.⁵

Зураг Т.11. Монгол Улс бүтцийн хувьд ижил түвшний болон зорилтот түвшний орнуудтай харьцуулахад нэг суралцагчид ногдох зардлаар бага хэдий ч суралцагчдын амжилт харьцангуй сайн байдаг.



⁵ “Энэ удаад өөрөөр: Тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн төлөөх төсвийн шинэчлэл” Монгол Улсын төсвийн судалгаа, 2025, Дэлхийн Банк

Нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн хүүхдүүдийн математикийн үнэлгээ нийгэм-эдийн засгийн статус дээгүүр хүүхдүүдийнхээс 94 оноогоор доогуур гарсан нь ЭЗХХАБ-ын дундажтай (93 оноо) ойролцоо байна. Үнэлүүлсэн 3 хичээлээр хот хөдөөгийн суралцагчдын дунд гарсан ялгаа нь (сумын хүүхдүүдийн 2 жилийн хоцрогдол) мөн л нийгэм-эдийн засгийн статусын нөлөөтэй гэсэн дүн гарчээ.

2021-2024 оны Боловсролын яамны статистик мэдээгээр 6-14 насны сургуулийн гадна байгаа хүүхдийн статистик (давхацсан тоогоор) 2020-2021 онд 776 (үүнээс 615 нь сургуульд огт ороогүй, 161 нь завсардсан, малчдын хүүхэд 114), 2021-2022 онд 987 (үүнээс 810 нь огт ороогүй, 177 нь ороод завсардсан, малчдын хүүхэд 108), 2022-2023 онд 656 (502 огт ороогүй, 154 ороод завсардсан, малчдын хүүхэд 89), 2023-2024 онд 454 (огт ороогүй 357, завсардсан 97, малчдын хүүхэд 231) хүүхэд байна.

Боловсролын Яам 3-18 насны хүүхдийн боловсролд хамрагдалтыг 100% хүргэх, нэг бүлгийн хүүхдийн тоог стандарт түвшинд хүргэх зорилтыг дэвшүүлж, 2028 он хүртэл 95 цэцэрлэг, 108 сургуулийг шинээр барьж, тавилга хэрэгслүүдийг хангахад 2.8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна.

Хүн бүрийн сурч боловсрох эрхийг баталгаажуулах Тогтвортой хөгжлийн зорилгын үзүүлэлтэд хүрэхийн тулд санхүүжилт зөвхөн барилга, бүтээн байгуулалт руу чиглэх нь хангалтгүй бөгөөд тэгш хамруулсан, эрх тэгш байдлыг баталгаажуулахад чиглэж нэгдсэн урт хугацааны бодлого, төлөвлөлтөд үндэслэн олон нийтийн хяналт, ил тод байдал, эгэх хариуцлагын механизмыг сайжруулахад анхаарах хэрэгтэй. Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгын эрх тэгш байдлыг санхүүжилттэй нь уясан **“хүн амын эмзэг хэсэгт боловсролын нөөцийг дахин хуваарилах санхүүжилтийн механизм байгаа эсэх”** гэсэн индикатор байдаг нь боловсрол дахь эрх тэгш байдлыг хангах буюу “хүүхэд бүрд амжилт гаргахад нь шаардлагатай байгаа нөөц, багш, үйл ажиллагаа, дэмжлэгийг үзүүлэх, санхүүжүүлэлт” хэрэгтэй.

Боловсролын бодлогоор олон улсын хөтөлбөрийн сургуулийг нэмэн байгуулж, олон улсын хөтөлбөрүүдийг турших, төрийн өмчийн сургуулийг сургалтын хэл, хөтөлбөр, санхүүжилтийн ялгаатай 2 давхаргат болгон хувааж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “хямд төлбөртэй” хотхоны бага сургууль байгуулах, боловсролын технологийн үйлчилгээг хувийн хэвшлүүдэд даатгах, төлбөртэй төрийн бус өмчийн сургуульд нэг хүүхдийн хувьсах зардал, багшийн мэргэжил дээшлүүлэх зардал зэрэг санхүүжилтийг улсын төсвөөс олгож, хувийн цэцэрлэгийн хувьсах зардлыг 2 дахин нэмэгдүүлж хуваарилж байгаа зэрэг нь боловсрол дахь тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх үр дагавартай байна.

Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг

Сүүлийн хориод жилд боловсролд нео-либерал зах зээлийн зарчим, хандлага илт нэвтэрснээр боловсрол олгодог хувийн хэвшлийн оролцогчдын тоо эрс нэмэгдсэн дэлхийн хөгжлийн чиг хандлагааас Монгол улс хоцроогүй юм.⁶ 2024-2025 оны хичээлийн жилд 885 ерөнхий боловсролын сургууль боловсрол, сургалтын үйл ажиллагаа явуулж байгаагаас 180 сургууль (20%) нь хувийн сургууль байна.⁷

2026 онд төрийн бус өмчийн СӨБ, ЕБС-ийн хувьсах зардал нийт 61.6 тэрбум төгрөг байхаар ТЕЗ-ийн саналд (төсвийн хязгаарыг харгалзан 11.3 тэрбум төгрөгөөр хэтрүүлж) тусгажээ.

Боловсрол дахь хувьчлал болон боловсролыг бизнес гэж үзэх хандлага өсөн нэмэгдэж буй нь олон улсын хэмжээнд сэтгэл зовоосон асуудал болж байна. Энэ нь дан ганц хувийн нэг (сайн, муу) сургуулийн асуудал биш харин хүүхэд бүрт үнэ төлбөргүй, чанартай боловсрол олгох төрийн үйл хэрэгт түүний үзүүлэх нөлөө, хувь нэмрийн тухай асуудал юм. Ялангуяа ашгийн төлөө болон төлбөр төлдөг боловсролыг өргөжүүлэх нь улс орон хүлээсэн үүргийнхээ дагуу нийтлэг чанар, тэгш байдал, чанартай боловсрол олгоход зориулах нэн хэрэгцээтэй санхүүжилт өөр тийш чиглэхийн зэрэгцээгээр боловсролын тогтолцоонд гадуурхал, тэгш бус байдал улам нэмэгдэх асуудлыг үүсгэж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага болон эрхийн байгууллагуудын зүгээс ашгийн төлөө хувийн сургууль байгуулахыг зэмлэн буруушааж байна. Хүний эрхийн болон боловсролын чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагуудын мэдэгдэл, үйл ажиллагаа дээрх эсэргүүцлийг улам хүчтэй болгож байна. НҮБ-ын Сурч боловсрох эрхийн тусгай илтгэгчид хувьчлалын эсрэг санал дэвшүүлсээр байна. Жишээ нь 2015⁸ онд “Боловсролыг нийтийн сайн сайхны төлөө үйлчлэхэд хувьчлал хор нөлөөтэй” гэж үзэж байсан бол 2016 онд НҮБ-ын тогтоолоор “Боловсрол ашгийн төлөө, арилжааны хэлбэрийн болсноос гарах аливаа сөрөг үр дагавар”-т анхаарч, боловсролын салбар дахь хувийн хэвшлийнхнийг төрөөс зохицуулахыг уриалсан байна⁹.

Боловсролын Ерөнхий хуулийн 18.2.-т “Боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус, эсхүл ашгийн төлөө байж болно.” гэж заасан байдаг ч хуульд “ашгийн төлөө”, “ашгийн төлөө бус” зорилго нь хэрхэн ялгагдах, үүнд үндэслэн холбогдох зохицуулалт ямар байхыг тодорхойгүй орхисон. Үүнийг тодотгож байж ашгийн төлөө, эсвэл ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй харьцах зохицуулалт боловсронгуй болох нөхцөл бүрдэнэ. Ялангуяа боловсролын салбарт улсын төсвөөс

⁶ Хувийн сургуулийг төрөөс зохицуулах шаардлага, Боловсрол эвсэл 2018 он

⁷ Боловсролын салбарын статистик мэдээлэл 2024-2025 он

⁸ Singh (2015) Report of the Special Rapporteur on the Right to Education
http://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/70/342

⁹ The Global Initiative for Economic, Social, and Cultural Rights has summarised all UNHR bodies' comments and observations adopted from September 2014 to June 2017: http://globalinitiative-escr.org/wp-content/uploads/2016/10/GIESCR-CRC_CESCR_CEDAW-synthesis-statements-on-private-actors-in-education.pdf

хувийн хэвшлийн боловсрол сургалтын байгууллагад дэмжлэг өгдөг нь энэхүү зохицуулалтыг нарийвчлах шаардлагыг үүсгэж байгаа билээ. Ерөнхийдөө боловсролын үйлчилгээг ашгийн төлөө хүргэдэг бизнесийн байгууллагад улсын төсвөөс татаас өгөх нь шударга ёс, эрх тэгш байдал, хүний эрхийн зарчмын үүднээс авч үзвэл маргаантай асуудал юм. Мөн энэ нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд заасан дараах 2 заалттай зөрчилдөнө.

- Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
- Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

Монгол улсын төр Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг конвенцууд, Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн Олон улсын пакт зэрэг хүний эрхийн олон тооны гэрээгээр сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хэрэгжүүлэх, хангах үүргийг хүлээсэн байдаг. “Төрөөс боловсролыг өөрөө хариуцан олгох, сургуулийн тогтолцоог байгуулж хөгжүүлэх үүргийг хүлээсэн байдаг ба энэ үүргээ хувийн оролцогчдод үүрүүлэн үүрэг хариуцлагаасаа чөлөөлөгдөх ёсгүй” гэдгийг Европын Хүний эрхийн шүүх шийдсэн байдаг. Тухайн улсад хувийн сургуулиуд үйл ажиллагаа явуулж байвал тэдгээр этгээдүүдээр нь хүний эрхийн зарчмуудыг мөрдүүлэх нь төрийн үүрэг хэвээр байна. Өөрөөр хэлбэл боловсролд хүнийг аливаа байдлаар ялгаварлан гадуурхахгүй, хүртээмжтэй, нийгмийн шударга ёсонд халгүй байх, тэгш бус байдлыг гүнзгийрүүлэхгүй байх үүргийг хувийн хэвшлийн оролцогчдод үүрүүлж байнга хянаж нягталж байх үүргээ төр биелүүлнэ. Боловсрол бол нийтийн сайн сайхны зүйл (public good) учир боловсрол нийтийн эрх ашигт үйлчлэх ёстой ба хувь хүний болон корпорейт ашиг сонирхолд үйлчлэх ёсгүй.


Монгол улсын Үндсэн хуулийн ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ хэмээх Хоёрдугаар бүлгийн Арван зургаадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно; гэж заасан байдаг. Энэ заалт нь хувь хүний хувийн сургууль байгуулах эрхийн тухай заалт биш эцэг эхчүүдийн хүүхдэдээ төрийн байгуулснаас өөр сургууль, тухайлбал, өөрийн шашин шүтлэг, ёс суртахууны итгэл үнэмшилд нийцсэн сургуулийг сонгож өгөх эрх чөлөөнөөс үүдэлтэй юм.

Дараагийн чухал санаа нь “төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль”-ийн тухай санаа бөгөөд төрөөс боловсролын үйлчилгээ үзүүлэгч хувийн оролцогчдод минимум стандарт тавьж, хангуулах, хянах, зохицуулах тухай асуудлыг хүний эрхийн гэрээгээр зөвшөөрсөн гэсэн үг. Тиймээс хуулиар бүх шатны сургуулийг байгуулахад тусгай шаардлагууд тавьж, хангасан тохиолдолд байгуулан ажиллуулах тусгай зөвшөөрлийг тодорхой хугацаагаар олгож, шаардлага хангасан тохиолдолд сунгаж, эс бөгөөс цуцалдаг эрхийг төрийн захиргааны төв байгууллага

болох Боловсролын яаманд өгсөн байдаг ч хувийн сургуулиудад хяналт тавьж чадахгүй байна.

2022 оны PISA үнэлгээгээр хувийн сургуулийн сургалтын чанар улсын сургуулийн сургалтын чанараас доогуур үзүүлэлттэй гарсан нь төр үүргээ биелүүлж хувийн сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших эрхийг хамгаалан хувийн сургуулиуд бодлогоор зохицуулж, сургуулийн орчин, нөхцөл, сургалтын чанарт хяналт тавих шаардлагатай.



Төр хувийн хэвшлийн түншлэл

Боловсролын технологи

Боловсролын салбарт төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд технологийн хэрэглээ, цахимжилт, AI хэрэглээг идэвхтэй дэмжин ажиллаж байна. Гэвч Монгол Улсын мэдээллийн технологийн салбарын өрсөлдөх чадвар дэлхийн дунджаас доогуур, мэдээллийн технологийн боловсрол, судалгаа, инновацын чадавх сул, цахим технологийн нэвтрүүлэлт, хэрэглээний түвшин хангалтгүй, өгөгдөлд шинжилгээ хийх, ашиглах чадавх хомс, Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сул байгааг Дэлхийн дижитал өрсөлдөх чадварын 2024 оны тайланд илтгэжээ.¹⁰ 2025 онд Боловсрол эвслийн хийсэн ЕБС технологийн хэрэглээтэй холбоо зардалд мониторинг хийхэд хэдийгээр интернет үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах хандлагатай байгаа ч ихэнх сургуулийн багш, сурагчид өөрсдөө дата авч холбогдох шаардлагагүй түвшинд очоогүй л байна. Илүү ноцтой нь сургуулийн байршил, хичээлийн байрны тоо зэргээс шалтгаалж сургуулиудын интернет үйлчилгээний хүртээмж, чанар ялгаатай байна. Мөн лицензийн төлбөртэй олон улсын хөтөлбөрийн платформуудыг хичээл, сургалтын үйл ажиллагаандаа ашиглахад цахим анги, таблет болон нөүтбүүкийн хүрэлцээ, хангамж муу,

¹⁰ Олон улсын менежмент хөгжлийн институт/Дэлхийн өрсөлдөх чадварын төв, Дэлхийн цахим өрсөлдөх чадварын эрэмбэ, 2024. Цахим хуваагдал: Эрсдэл ба боломж, 147 дахь тал. Мөн тус бүлгийн “Иргэдийн цахим боловсрол, цахим ур чадвар” хэсэг

интернетийн хурд удаан байсаар байгаа нь тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх эрсдэлтэй байгааг илрүүлсэн.

- Сургуулиудад цахим хэрэглээний зардлын төсөв өгдөг болсон нь сайшаалтай ч хэрэгцээ их байгаа тул хүрэлцээ тааруу байна. Сурагчийн тооноос хамаарч төсөв ирж байгаа тул цөөн сурагчтай сургуулиудын хувьд төсвийн хүрэлцээ илүү муу.

- Мэдээллийн технологийн мэргэжлийн ажилтан сургуульд байдаггүй нь интернет, дотоод сүлжээ, цахим тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотой асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж чадахгүй байхад нөлөөлж байна.

- Таблет, нөүтбүүк, хромбүүк зэрэг цахим тоног төхөөрөмжийн эрүүл ахуй, ариун цэвэр - хүрэлцээгүй байдлаас болж тэднийг цахим ангидаа төвлөрүүлсэн байдаг бөгөөд 5 минутын зайтай л сурагчид солигдон тоног төхөөрөмжийг ямар ч ариутгал, нөхөж сэлбэх байтугай цэнэглэх боломж ч олгохгүй ашиглаж байна. Энэ нь тэдгээрийн ашиглалт, эдэлгээнд мөн сөргөөр нөлөөлж байна.

- Нөхөн хангалтын зардлын төсвийг ихэвчлэн цахим анги байгуулах, цахим тоног төхөөрөмж авах зэргээр зарцуулж байна.

- Нөхөн хангалтаар засвар үйлчилгээ хийх төсвийг мөн зөвшөөрдөг болох хэрэгтэй. ¹¹

- Эдүтэн: 2023 онд 857,396,628 төгрөг, 2024 онд 1,472,946,096.08 төгрөг /суралцагч нэг бүрд 2.99 евротой тэнцэх зардал/
- Пийрсон англи хэл: 2023-2024 оны хичээлийн жилд 4,780,478,181 төгрөг, 2024-2025 оны хичээлийн жилд 2,860,792,000 төгрөг
- Сураад.мн: 2022-2024 онд 888,146,225 төгрөг
- LMS, SMS: 2022-2024 онд 8.3 тэрбум төгрөг
- Нийт /2022-2024 он/: 19.2 тэрбум төгрөг буюу боловсролын салбарын урсгал зардлын 0.1-0.3% (Эх сурвалж: БЯ)
- Цаашдын төлөв (жил бүр)

Хөтөлбөр/платформ	Хамрагдах сурагчийн тоо	Шаардагдах төсвийн төсөөлөл
Эдүтэн	343,289	3,765,104,016.26
Пийрсон	588,093	6,469,023,000.00
Сураад.мн	378,469	8,721,738,807.20
LMS/SMS	-	2,766,666,666.67
Нийт		21,722,532,490.12
Боловсролын салбарын урсгалд зардалд эзлэх хувь		0.65%

12

Хотхоны бага сургууль концепц

«Бага төлбөртэй» хувийн сургуулиуд, тусгай эрх олгосон сургуулиуд, ваучерийн болон “сүүдрийн” (shadow education system) боловсролын байгууллага, сургуулиуд

¹¹ “ЕБС-ийн цахим хэрэглээ, нөхөн хангалтын төсвийн зарцуулалт” тайлан, “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл, МБШУҮЭХ, 2025

¹² Эх сурвалж: “ЕБС-ийн цахим хэрэглээ, нөхөн хангалтын төсвийн зарцуулалт” тайлан, “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл, МБШУҮЭХ, 2025

өсч байна. Бага төлбөртэй гэх хувийн сургуулиуд байгуулах, төр болон хувийн хэвшлийн түншлэл нэрийн дор “төрийн” сургуулиудыг хувийн хэвшил удирдаж ажиллуулах, заримдаа тусгай эрхтэй нэрийн дор ашгийн төлөө ажиллах, эсвэл тусад нь засгийн газрын буцалтгүй тусламж үзүүлж, хувийн сургуулийн төлбөрийг төлөх буюу татаас олгох, мөн хичээлээс гадуурх төлбөртэй сургалт явуулдаг «сүүдрийн» хэлбэрээр ажиллаж байна. Боловсролын салбар дахь хувийн хэвшлийн эдгээр хэлбэрүүд өргөжсөнөөр тэдэнд нэлээд ашигтай байж болох ч, боловсрол эзэмших эрхийг зөрчихөд хүргэж, бүх нийтээр тэгш шударга, чанартай боловсрол эзэмшихэд илэрхий саад тотгор учруулдаг.¹³ Монгол улсад Хотхоны бага сургууль концепцийн хүрээнд 2025 оны 9 сараас Улаанбаатар хотын бүлэг дүүргэлт өндөртэй Баянгол, Хан-Уул, Баянзүрх дүүргийн зарим байршлын томоохон хороолол, хотхонуудад бага төлбөртэй бага сургууль байгуулж эхэлж байгаа нь нийтийн боловсролын эрх тэгш, чанартай боловсрол эзэмших эрхэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэв.

¹³ Хувийн сургуулиудыг төрөөс зохицуулах шаардлага, Боловсрол эвсэл 2018

VI. ИРГЭНИЙ НИЙГМИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Боловсролын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, 2030 он хүртэл тогтвортой хадгалах

- Боловсролын салбарын төсвийн улсын төсөвт эзлэх хувийг нэмж, Инчоны тунхаглалд (2015) заасны дагуу төсвийн зардлын 20%, ДНБ-ий 6% -иас доошгүй хэмжээнд¹⁴ жил бүр хүргэж, 2030 он хүртэл тогтвортой хадгалах,
- хөгжингүй орнууд нэг суралцагчид 6-15 насанд нь өсөн нэмэгдэх дүнгээр дунджаар 91,132 ам.доллар зарж байхад Монгол улс 12,576 ам, доллар зарж байгааг анхаарч, нэг суралцагчид ноогдох зардлыг эрчимтэй нэмэгдүүлэх замаар боловсролын чанарыг сайжруулах,
- Сургууль, цэцэрлэгийг санхүүжүүлж байгаа нэг суралцагчид ноогдох хувьсах зардлын хэмжээг Боловсролын ерөнхий хуулийн 24 дугаар зүйлийн 1.7 дугаар заалтын дагуу 2 жил тутам дорвитой нэмэгдүүлэн тогтоож байх
- Боловсролын төсвийн шинэчлэлийн бодлогыг тогтвортой үргэлжлүүлэх санхүүжилтийг хуваарилах, ялангуяа сургууль, цэцэрлэгүүдийн өдөр тутмын сургалтын үйл ажиллагааг хангалттай санхүүжүүлэх түвшинд хүргэтэл Сангийн яам төсвийн шинэчлэлийн бодлогын залгамжийг хадгалахад үүрэг хүлээх
- Монгол Улсын боловсролын салбарын зардалыг өндөр болгодог халаалт дулааны, дотуур байрны зардал, гадаад оронд сургах тэтгэлэг зэрэг онцлог байдлыг харгалзан судлаачдын санал болгосноор боловсролын салбарын санхүүжилтийг улсын төсвийн 20%-иас доошгүй хувь байхаар хуульчлах,
- Төсвөөс сургууль дээрх хөгжлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийг санхүүжүүлэх нэмэлт тэтгэлэг олгох. Ихэнхдээ жижиг тэтгэлэг хэлбэрээр тоног төхөөрөмж худалдан авах, багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа зэрэг зориулалтаар, зарим тохиолдолд дэмжлэг шаардлагатай орон нутаг эсвэл суралцагчид зориулан олгодог.
- Боловсролын санхүүжилтийн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан нийгэм-эдийн засгийн статус доогуур өрхийн суралцагчид болон тэдний гэр бүлийг мөнгөн хэлбэрээр (жишээ нь: тэтгэлэг) болон төлбөр (жишээ нь: сургалтын төлбөр)-өөс чөлөөлөх байдлаар тусгайлан чиглэсэн дэмжлэг үзүүлэх.
- Сургалтын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх буюу боловсролын чанарт нөлөөлөх санхүүжилтийг танахгүй, бууруулахгүй байх:
 - Хичээл практикийн зардал
 - Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил
 - Багшийн цалин хөлс, ажлын нөхцөл
 - Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын суралцахуйд тулгарах саадыг арилгах болон суралцахуйг дэмжих тогтолцоо, үйлчилгээ

¹⁴ Ослогийн тунхаглал (2008)

- Хөтөлбөр, сурах бичиг, сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн
- Багш – бэлтгэл, мэргэжлийн тасралгүй хөгжил
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боломжит тохируулга, дэмжлэгийн тогтолцоо, үйлчилгээ
- Боловсролын орчныг хүүхэд бүрт хүртээмжтэй болгох Хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэх
- Хүүхэд бүрт хүрч үйлчилдэг Улсын сургууль, цэцэрлэгээ бэхжүүлэх төсвийн хуваарилалт хийх, тусгай сургууль, цэцэрлэг нэмж барих байгуулахгүй байх
- Боловсролын салбарт сурагчдын амжилтын ялгааг багасгах зорилтот хөрөнгө оруулалт хийх. 2028 он гэхэд боловсролын салбарын үр ашиг 65.7 хувиас 86.1 хувь болж нэмэгдэх боломжтой бөгөөд нийгэм-эдийн засгийн бүлгүүдийн доод 40 хувьд хамаарах сурагчид 20 хувийг эзэлж буй дээд бүлгийнхтэй ойролцоо амжилтад хүрэх боломжтой хэмээн тооцоолж байна. Ийнхүү сайжруулах нь Монгол Улсын Сурлагын Амжилтын Олон Улсын Үнэлгээ (PISA)-ний дундаж оноог ЭЗХАХБ-ын (ЭЗХХАБ) дунджаас давуулах боломж олгохоос гадна боловсролын чанарыг бүхэлд нь чанаржуулж, суралцагчдыг дэлхийн өрсөлдөөнт хөдөлмөрийн зах зээлд амжилттай нэвтрэх бэлтгэлийг илүү сайн хангахад түлхэц болох юм.

2. Улсын төсвийн хэмжээг нэмэгдүүлэх

- Эдийн засгийн чадавх, орлогын хэмжээг харгалзан ялгаатай хувь хэмжээгээр шаталсан татвар ногдуулах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх, улмаар төсвийн алдагдал, өрийн дарамтын ачаалал буурч, инфляцад эерэг нөлөө үзүүлж, нийтийн ашиг сонирхлын зорилгоор боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг нийгмийн хөгжлийн салбаруудад тэгш, үр нөлөөтэй зарцуулах нь эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг нийт хүн амд тэгш, хүртээмжтэй хуваарилах боломжийг нээх
- Хувь хүний орлогын албан татвар болон онцгой алыан татварын орлогын төвлөрүүлэлт сул гүйцэтгэлтэй байгааг анхаарч, татварын орлогыг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авах
- Тамхи болон согтууруулах ундааны онцгой албан татварыг нэмэгдүүлэх, ингэснээр архи, тамхины хэрэглээг бууруулах, холбогдох өвчлөл, нас баралтыг багасгах, мөн боловсролын салбарыг санхүүжүүлэх төсвийн нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгох боломжтой.
- Чинээлэг өрхүүдэд илүү үр өгөөжтэй байдаг нэмүү өртгийн албан татварын чөлөөлөлт, эсвэл татварын хувийг бууруулах зэрэг бодлогын арга хэлбэрээс татгалзах

- Татварын өр томоохон асуудал болоод байгааг хүлээн зөвшөөрч, торгуулийг шударгаар ногдуулан, татварын өрийн удирдлагыг бэхжүүлж, маргаан шийдвэрлэх болон эрсдэлд суурилсан аудитыг сайжруулснаар татварын даган мөрдөлтийг сайжруулах
- Эдийн засгийн өршөөл, татварын өршөөл нь

3. Боловсролын төсвийн мэдрэг байдлыг дээшлүүлэх

- Тэгш байдлыг нэмэгдүүлэх үүднээс хувийн сургуулиудад чиглэсэн нэг сурагчид ногдох төрийн санхүүжилтийг нийгэм-эдийн засгийн хувьд эмзэг бүлэгт хамаарах хүүхдүүдэд зориулан, улсын сургуулиудад тулгарч буй нөөцийн дутагдлыг нөхөхөд шилжүүлэн ашиглах, Хувийн сургуулиудын төрөөс авч байгаа бага санхүүжилт нь өндөр орлоготой өрхийн хүүхдүүдэд очих байгаа тул төрийн санхүүжилтийг нийгэм эдийн засгийн бүлгийн доод 40 хувьд багтах хүүхдүүдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд чиглүүлснээр жил бүр 60 тэрбум төгрөг (ойролцоогоор 17.3 сая ам.доллар) хэмнэгдэх боломжтой.
- Боловсролын ялгаатай хэрэгцээ – одоогийн санхүүжилтийн тогтолцоонд хөгжлийн бэрхшээлийг анхаарч үзэж байгаа хэдий ч хангалтгүй байна. Хэдийгээр эрхзүйн хувьд нөхцөл нь бүрдсэн боловч тусгай сургуулийн суралцагчдад энэ боломж хүрч, ердийн сургуульд суралцаж байгаа хүүхдүүдэд хүртээмжтэй биш хэвээр байна.
- Тухайн сурагчийн эх хэл – Зөвхөн Баян-Өлгий аймагт суралцаж байгаа казак хүүхдүүдээс гадна хэлний цөөнх тува хүүхэд, дохионы хэлээр суралцаж байгаа суралцагчийн хувьд сурах эрхээ эдлэхэд шаардагдах зардлуудыг гаргах санхүүжилт
- Боловсролын санхүүжилтийн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан суралцагчид болон тэдний гэр бүлийг мөнгөн хэлбэрээр (жишээ нь: тэтгэлэг) болон төлбөр (жишээ нь: хоолны төлбөр)-өөс чөлөөлөх байдлаар тусгайлан чиглэсэн дэмжлэг үзүүлэх.
- Сурлагын хоцрогдолтой аймгуудад багш-сурагчийн харилцаа, хамтын ажиллагааг сайжруулж, сургалтын үргэлжлэх хугацааг уртасгаж, бүс нутгийн боловсролын ялгааг бууруулахад дэмжлэг үзүүлэх боломжтой.
- Монгол Улс бүх 5 настай хүүхдийг улсын цэцэрлэгийн бэлтгэл ангид хамруулахыг эрхэмлэж, цаашид нийгэм, эдийн засгийн бүлгийн доод 40 хувьд хамаарах 3-4 настай хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэхийг зорих ёстой.

- Боловсролын санхүүжилтэд орон нутгийн болон сургууль, цэцэрлэгийн онцлогийг тусгах
- Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийн тооцоолол, аргачлалыг тасралтгүй сайжруулах
- Орон нутгийн онцлогийг тусган илүү нарийвчлах шаардлага
 - Сургуулийн/орон нутгийн онцлог
 - Суралцагчийн/гэр бүлийн онцлог
 - Орхигдсон, гадна үлдсэн/орхигдох, үлдэх магадлалтай бүлгүүдийн сурч боловсрох эрхийг дэмжихэд чиглэсэн санхүүжилт
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах чиглэлээр, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдүүдийн Тохируулгын зардлыг төсөвт хувьсах зардлаас гадна нэмэлтээр сургууль, цэцэрлэг бүрт тусгах, эсвэл аймаг дүүргийн Боловсролын газарт нэмэлтээр тусгах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Боловсролын төсөвт оруулан авдаг хувьсах зардлыг 3 дахин нэмэгдэлтэйгээр Боловсролын Сургалтын байгууллага бүрт бүрэн хуваарилах.
- Сургуулийн онцлогоос хамааралтай хүчин зүйлсийг тооцсон итгэлцүүр
 - Алслагдсан байдал: Тухайн сургууль болон аймгийн төв, аймаг болон Улаанбаатарын хоорондох зай болон нөхцөл бөгөөд жишээлбэл үүнийг тооцохдоо хоорондын зайгаар бус туулах цагаар нь тооцох
 - Төвлөрсөн хангамжид холбогдсон байдал: Тухайн сургууль халаалт, цахилгаан, ус болон бохирын шугамд холбогдсон эсэхээс хамаарна.
 - Дотуур байранд амьдарч байгаа суралцагчид - малчдын хүүхэд 24 цагаар 9 сар амьдарч байгааг тооцон, хүүхдийн суралцах, хөгжих, хамгаалуулах эрэлт хэрэгцээг хангах үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хуваарилах
 - Сургуулийн хэмжээ/суралцагчийн тооноос хамаарсан итгэлцүүр: Тухайн сургуульд суралцаж байгаа хүүхдийн тооноос нь хамаараад шаталсан итгэлцүүрээр тооцох. Цөөн суралцагчтай /500 ба доош/ сургуульд тодорхой итгэлцүүрээр зардлыг нь нэмж олгодог бол олон суралцагчтай /2000 ба дээш/ сургуульд итгэлцүүр нь багасах
 - Боловсрол олгох түвшнээр ялгаатай итгэлцүүр: Бага, дунд, ахлах – ахлах ангид илүү их зардал гарах шаардлагатай болдог гэх мэт
 - Суралцагчийн онцлогоос хамааралтай хүчин зүйлс: хамгийн чухал бөгөөд эрх тэгш байдалтай холбоотой - хүүхэд бүрийг амжилттай суралцаж, хөгжих боломжийг тэнцвэржүүлэхэд түлхэц болно.
 - Тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн статус – тухайн сургууль оршин байгаа орон нутгийн ядуурлын түвшнийг харгалзаж тооцох

- Цахим тоног төхөөрөмж, интернет, датагүй байхгүйгээс суралцахуйн хоцрогдол үүсэх эрсдэлтэй байгаа сурагчид

4. Санхүүжилтэд тавих хяналт

- Хамааралтай талууд, тэр дундаа эцэг эхийн гүйцэтгэх үүргийг илүү хүчтэй болгох, бусад хамааралтай талын оролцоог утга учиртай болгох –

Орон нутгийн боловсролын бүлэгт LEG - (Яамны түвшинд):

- Боловсролын салбарт хөгжлийн албан ёсны тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хяналт тавих эрх
- Боловсролын сайдын хөтөлбөр, арга хэмжээнд санал, зөвлөмж өгөх, хэрэгжилтэд хяналт тавих эрх
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын тайланг сонсох, хэлэлцэх
- Боловсролын салбарын төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлэхээс өмнө, УИХ-д өргөн барихын өмнө танилцуулж, ИНБ, ҮЭ-ээс санал авдаг, зөвлөлддөг байх...

Орон нутгийн түвшинд (аймаг орон нутгийн түвшинд):

- Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн санал, хуваарилагдаж ирсэн төсвийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих эрх
- Ашиглалтын зардлыг орон нутгийн түвшинд зөвлөлөөр шийдэх, хяналт тавих.
- Хүүхэд бүрийн сурч боловсроход саад болж буй хүчин зүйлсийг арилгах нөхцөлийг бүрдүүлэх:
- Орон нутгийн түвшинд сургуулийн барилга байгууламж, түүний ашиглалт, урсгал засварын байдалд хөндлөнгийн үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэх ажлыг ИНБ-уудаар гэрээлэн гүйцэтгүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.1-д заасан сургалтын орчныг бүрдүүлэхэд зориулж орон нутгийн төсөвт туссан зардлын гүйцэтгэлийг хянах
- Хос хэлний боловсролын бодлогын чиглэлийн хэрэгжилт
- Боломжит тохируулга, дэмжлэгийн тогтолцоо, үйлчилгээний санхүүжилтийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих

Сургуулийн зөвлөл, Эцэг эхийн зөвлөл, холбоо (сургуулийн түвшинд):

- Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, санхүү, өөрийн үйл ажиллагаанаас орсон орлого, сургууль хөгжүүлэх сангийн зарцуулалтыг хянах эрх (багш, суралцагчийн нэгэн адил)
- Сургууль дахь хичээл практик, урсгал засварын зардал, хөгжлийн бэрхшээлтэй ба үндэсний цөөнх хүүхдэд өгөх нэмэлт санхүүжилтийн төсөвлөлтөд эцэг эхийн байгууллагыг оролцуулах, зарцуулалтад хяналт тавих эрх олгох
- Сургалтын тоног төхөөрөмж, үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол, зөөлөн эдлэл, халаалт түлш зэрэг худалдан авалтын үйл явцыг тодорхой болгох, худалдан авалтын үе шатанд, ялангуяа хяналт тавихад эцэг эх, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл зэрэг нэмж оруулах

. . .